



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 806

Шивээговь сум

Сумын 2023 оны газар зохион байгуулалтын  
тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Газрын харилцаа, барилга геодези, зураг зүйн газрын даргын 2010 оны 497 дугаар тушаал “Сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын орлогч

Гишүүд:

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Газрын даамал

2. Хот тосгон бусад суурины газрыг эзэмшүүлэх, ашиглуулах төлөвлөгөө боловсруулах, бэлчээрийн газрын даац тогтоох, бэлчээрийн сэлгээ хийх, хамгаалах, бэлчээрийг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, малчдын өвөлжөө, хаваржааны газрыг төлөвлөх, суурь судалгааг боловсруулахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.

3. 2023 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажлын явцыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д даалгасугай.





Сумын Засаг даргын 2022 оны 01-р  
сарын 14-ний өдрийн 106 дугаар  
захирамжийн хавсралт

## Сумын 2023 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамж

**1. Зорилго :** Сумын газар нутгийн хэмжээнд хичнээн хэмжээний газрыг хаана, ямар зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх нөөц боломжийг тодорхойлсны үндсэн дээр зүй зохистой, оновчтой, бүрэн дүүрэн ашиглалтыг буй болгох зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичгийг боловсруулахад оршино.

**2. Хэрэгжүүлэх хугацаа:** Газрын тухай хуулийн 25.4-т зааснаар тухайн жилийн төлөвлөгөөг жилдээ хэрэгжүүлэх бөгөөд 2022.01.01-2022.11.01 хүртэл

**3. Баримтлах чиглэл, зарчим :** Тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд дараах үндсэн асуудлыг шийдвэрлэнэ.

3.1 Газар ашиглагч, эзэмшигч өмчлөгчдийн газрын оновчтой, зөв зохистой хэмжээ, бүтцийг нь тогтоож эрх зүйн баталгааг хангахын тулд тухайн жилд өмчлүүлэх, эзэмшүүлэх ашиглуулах газрын байршил хэмжээг тогтоох

3.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын асуудлыг орон нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлалтай уялдуулан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн хувиарийн дагуу зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг тусган арга хэмжээг зохион байгуулах, хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах арга хэмжээг төлөвлөх.

3.3 Газрыг уул уурхайн болон бусад төрлийн элэгдэл, эвдрэл, бохирдолт, цөлжилтөөс хамгаалах, сэргээн сайжруулах, байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, элэгдсэн болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон арга хэмжээнүүдийг авах.

3.4 Усан сан болон ойн зурvas байгуулах газрыг оновчтой дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулах.

3.5 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг Орон нутгийн хөгжлийн санд төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах.

3.5 Газар ашиглалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор доороос нь дээш нь чиглэсэн, хэрэгжих магадлалтай боловсруулсан байна.

3.6 Тухайн жилийн төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, нөхөн сэргээхэд болон бусад зураг төсөл, төлөвлөлт, зохион байгуулах ажилд тулгуур материал болгон ашиглагдана.

### 4. Тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах дараалал, түүнийг баталгаажуулах :

4.1 Сумын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг боловсруулан сумын Засаг даргаар батлуулах

4.2 Сумын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг 1, 2 дугаар багийн иргэд, малчдын нөхөрлөл, бүлгүүдэд хүргэх ойлгуулах.

4.3 Сумын 2 дугаар багийн газар нутгаар ажлын хэсэг маршрут гарган хэмжилт хийн, Бэлчээрийн даацыг тодорхойлон хээрийн судалгааг боловсруулах

4.4 Аж ахуйн нэгж, байгууллага, багийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлөөс “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд оруулах саналыг авах.

4.5 Бэлчээр ашиглалтын хэсэгт хамрагдаж байгаа малчид бэлчээрээ өнжөөж амраах, сэлгэж ашиглах, усжуулах отор нүүдэл хийх, бэлчээрээ хамгаалах талаар малчдад ухуулга сурталчилгаа хийж малчитдай зөвшилцөнө.

4.6 Барилга байгууламжын дэвсгэр газар болон, Бэлчээр ашиглалтын хэсэг, өвөлжөө, хаваржаа, худаг уст цэг, хадлан тариалан, бэлчээрийг өнжөөх сэлгэх хамгаалах, зэрэг судалгаа бичмэл тайлангаа зурган хэвлэлд хөврүүлэх.

4.7 Сумын Газрын даамал нь ГХБГЗЗГ даргын 497 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийсэн сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн нэгдсэн төлөвлөгөөний төслийг зураглалын хамт сумын Засаг даргад өргөн мэдүүлнэ.

### **1. Ажлын үе шат:**

5.1 Бэлтгэл үе шат

5.2 Хээрийн судалгаа хийж, төлөвлөх үе шат

5.3 Тухайн жилийн “Газар зохион байгуулалт” цаашид авах арга хэмжээ, сумын хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулах

5.4 ИААНБ-аас санал авч нэгтгэх ажлын хэсгээр хэлэлцүүлэх, Сумын ИТХ-аар батлуулах

5.5 Холбогдох зураг, хүснэгтэн баримт материал, тооцоо, тайланг бүрдүүлэх

5.6 Хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих гэсэн үе шатнаас бүрдэх ба дараах төрлийн суурь судалгаа, төлөвлөлтийн шийдлүүдийг багтаана.

### **2. Гарах баримт бичиг:**

6.1 Тайлан

6.2 Төлөвлөөгний нэгдсэн зураг

6.3 Сэдэвчилсэн бусад зураг / бэлчээрийн даац, хөрс, ургамал /

6.4 Тооцоо судалгааны тайлан / хүснэгт, диаграмм/

## **АЖЛЫН ХЭСЭГ**